



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 04 өдөр

Дугаар A/295

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай” 78 тоот зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай” 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” 71 дүгээр тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны “Журам батлах тухай” А/316 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутныг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/219 дүгээр тушаалын Хишигсүрэн овогтой Номинд холбогдох хэсгийг Чулуунзоригт овогтой Цогjavхланда, Канад улс, Торонтогийн их сургууль, математик, физикийн шинжлэх ухаан 4 жил, Батмөнх овогтой Шурд холбогдох хэсгийг Мөнхцэнгэл овогтой Мөнхбилэг, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Манчестерийн их сургууль, Олон улсын бизнес, санхүү эдийн засаг, 3 жил, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/215 дугаар тушаалын Занданшатар овогтой Должинсүрэнд холбогдох хэсгийг Онондорж овогтой Анударь, АНУ, Массачусетсийн Их сургууль, Олон улсын бизнесийн удирдлага, 4 жил гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Олон улсын төсөл, хөтөлбөр гадаад хамтын ажиллагааны газар /Т.Уганбаяр/-т тус тус даалгасугай.

САЙД

ЦОГЗОЛМАА



0901397